

БУЛГАН АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Тайлан хянасан : Дарга

Б.БАТТУЛГА

Тайлан бичсэн: Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах
байцаагч

Д.САРАНГЭРЭЛ

2016 ОН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН
ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Тайлан нь БУЛГАН АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА- ны үйл ажиллагааны үр дүнг 2016 оны байдлаар иж бүрэн, үнэн зөв илэрхийлсэн гэж үзэж байна.

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Б.БАТТУЛГА

Боловсруулсан : Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах
байцаагч Д.Сарангэрэл

2016 оны 12 дугаар сарын 09-ний өдөр

БУЛГАН АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН
АЛБАНЫ 2016 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Орон тоо: Тус алба нь бүтэц орон тооны хувьд албаны дарга улсын ахлах байцаагч 1, улсын ахлах байцаагч 1, улсын байцаагч, нягтлан бодогч 1, улсын байцаагч нярав, бичиг хэрэг 1, улсын байцаагч 1 орон тоотойгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын 303 тоот өрөөнд байрлан үйл ажиллагаагаа явууллаа. 5 ажилтан 1250 хүн өдөр бүрэн ажилласан байна.

Сургалт, семинар, мэргэжил арга зүйн зөвлөгөө: Хууль тогтоомжийг санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, ММНБИ-ийн Булган салбартай хамтарч аймгийн хэмжээнд нягтлан бодогчид, нярав нарыг хамруулан зохион байгуулсан сургалтад хамрагдав.

Дээрхи сургалт үр дүнгээ өгсөн ч сонгуулийн үр дүнгээр байгууллагын менежерүүд солигдсон тул ирэх онд санхүү төсвийн холбогдолтой болон шилэн дансны талаар сургалтыг дахин зохион байгуулах шаардлагатай байна.

Байцаагчийн боловсрол, мэдлэгийг хэрхэн дээшлүүлсэн байдал: Тайлант хугацаанд 3 улсын байцаагч мэргэшсэн нягтлан бодохын сургалтанд сууж, 1 байцаагч мэргэшсэн нягтлан бодогч боллоо.

Аймгийн Засаг даргын тамгын газар, бусад байгууллагын зохион байгуулсан 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 5 улсын байцаагч хамрагдав.

Улсын салбарын дотоод аудитуудын анхдугаар зөвлөгөөн, Санхүүгийн хяналт дотоод аудитын ажилтны бүсийн сургалтанд 4 ажилтан хамрагдсан байна.

Мөн хяналт шалгалтын үр дүнг сурталчлах, иргэдэд сэрэмжлүүлэг хүргэх зорилгоор 2 зөвлөмж үйлдэж, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тогтоол, заавар журмын эмхэтгэл ном захиалан 100 аж ахуйн нэгж, байгууллагад тараалаа.

Ил тод байдлын хүрээнд: Vulgan gov.mn вэб сайтад цаг үе, үйл явдлын мэдээ, хяналт шалгалтын мэдээг байршуулсан ба sankhuu audit bu fase хуудсаар хяналт шалгалтын дүн болон ээлжийн амралтын олговор олгох , албан томилолтын зардал бодох зөвлөмжүүд боловсруулан мэдээлсэн.

Байгууллагын мэдээллийн самбарт холбогдох хууль тогтоомж, төсвийн хуваарь, сар, улирлын мэдээг байршуулж байгаа болно.

Хүний нөөцийн бодлогын талаар: Нийт 3 ажилтанд зэрэг дэв олгох санал хүргүүлж зэрэг дэвийн нэмэгдлийг 2016 оны 02 дугаар 01-ээс олгохоор шийдвэрлэсэн.

Тайланд онд давхардсан тоогоор 5 хүнийг шагнуулахаар уламжилж, шагнагдсан. Тухайлбал: Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч медалиар 1, Аймгийн Тэргүүний ажилтан цол тэмдэгээр 2, аймгийн ИТХ-ын Жуух-аар 1, баярын бичгээр 1 ажилтан тус тус шагнагдсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан цол тэмдэгээр шагнуулахаар 1 хүний материалыг бүрдүүлэн Сангийн яаманд хүргүүлээд байна.

Хоёр. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, илэрсэн асуудлууд

Асуудал 1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан

Шалгуур: Батлагдсан төсвийн хүрээнд төсвийг зориулалтын дагуу зарцуулна.

Бодит нөхцөл байдал: Могод сумын Цэцэрлэг 50,0 мянган төгрөг, Хангал сумын Цэцэрлэг 28,5 мянган төгрөг, Хангал сумын суурь боловсролын сургууль 997,0 мянган төгрөг, Хангал сумын ИТХ 360,0 мянган төгрөг, Хангал сумын ЗДТГ 550,0 мянган тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Үр нөлөө: Төсвийг зориулалт бусаар зарцуулж байгаа нь төсвийн тухай хууль тогтоомж хэрэгжихгүй байдалд хүрч байна.

Асуудал 2. Татвар, шимтгэл дутуу тооцсон:

Шалгуур: Хууль тогтоомж хэрэгжсэн байна.

Бодит нөхцөл байдал: Могод сумын газрын төлбөр 418,1 мянган төгрөгөөр, Хангал сумын газрын төлбөр 273,3 мянган төгрөгөөр, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар 181,4 мянган төгрөгийн ЭМНДШ дутуу тооцсон

Үр нөлөө: Төсвийн орлогод нөлөөлсөн

Асуудал 3. Үндсэн баримтгүй зарцуулсан, данс бүртгэлд тусгаагүй

Шалгуур Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно

Бодит нөхцөл байдал: Хангал сумын Соёлын төв 119,6 мянган төгрөг, Баяннуур сумын Цэцэрлэг 170,6 мянган төгрөг, ГХБХБГ 235,0 мянган төгрөг, Могод сумын ЭМТ 174,7 мянган төгрөг, Хангал сумын ЭМТ 470,7 мянган төгрөг, Хангал сумын СБС 18,1 мянган төгрөг, Булган сумын 6-р Цэцэрлэг 73,6 мянган төгрөг, 7-р Цэцэрлэг 473,3 мянган төгрөг, Тэшиг сумын сургууль 219,5 мянган төгрөг, Хялганат тосгоны ЭМТ 49,7 мянган төгрөг, Бүрэн дунд сургууль 180,0 мянган төгрөг нийтдээ 2184,8 мянган төгрөгийн үндсэн баримтгүй зарцуулсан байна.

Үр нөлөө Анхан шатны баримтгүйгээр төсвийн хөрөнгө зарцуулж байна..

Асуудал 4. Дутуу болон илүү олгогдсон цалин хөлс, нөхвөр

Шалгуур Цалинг Засгийн газрын тогтоол, албан томилолтыг сангийн сайдын тушаалын дагуу батлагдсан төсвийн хэмжээнд олгох

Бодит нөхцөл байдал: Могод сумын Цэцэрлэг 777,4 мянган төгрөг, Хангал сумын Соёлын төв 1647,8 мянган төгрөг, Хангал сумын Цэцэрлэг 1633,9 мянган төгрөг, Баяннуур сумын Цэцэрлэг 763,8 мянган төгрөг, Могод сумын ЭМТ 29,0 мянган төгрөг, Могод сумын СБС 1553,9 мянган төгрөг, Могод сумын ЗДТГ 193,5 мянган төгрөг, Булган сумын 6-р Цэцэрлэг 414,8 мянган төгрөг, Тэшиг сумын

Соёлын төв 14,0 мянган төгрөг, Тэшиг сумын Цэцэрлэг 5079,8 мянган төгрөг, Тэшиг ЭМТ 4445,9 мянган төгрөг, Тэшиг Бүрэн дунд сургууль 7125,2 мянган төгрөг, Тэшиг ИТХ 869,5 мянган төгрөг, Тэшиг ЗДТГ 3347,6 мянган төгрөг, ХХҮГ 1330,8 мянган төгрөг, 7-р цэцэрлэг 2297,2 мянган төгрөг 2297,2 мянган төгрөг Хялганат тосгоны Цэцэрлэг 634,9 мянган төгрөг, Хялганат тосгоны 919,5 мянган төгрөг, Хялганат Захирагчийн алба 75,0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ 1258,6 мянган төгрөг нийт 34412,1 мянган төгрөгийн цалин томилолт илүү олгосон байна.

Үр нөлөө Нягтлан бодогчийн хариуцлагагүй үйл ажилагаанаас шалтгаалан илүү дутуу олгох зөрчил багасахгүй байна.

Асуудал 5. Ашиглаж дутагдуулсан хөрөнгө

Шалгуур Төсвийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх

Бодит нөхцөл байдал: Булган сумын 1-р сургууль 3515,1 мянган төгрөг, Хишиг-Өндөр сумын Сум дундын эмнэлэг 5577,4 мянган төгрөг, Булган сумын 7-р Цэцэрлэг 5,4 мянган төгрөг нийт 9097,9 мянган төгрөгийг ашиглаж дутагдуулсан байна.

Үр нөлөө Дээрхи 9097,9 мянган төгрөгийг тухайн байгууллагууд боломжит өөр зардлуудад зарцуулах боломж алдагдсан.

Асуудал 6: Төсвийн хөрөнгийг бусдад зээлдүүлж түр ашиглуулсан.

Шалгуур: Зээл эргэн төлөгдсөн байна.

Бодит нөхцөл: Могод сумын сум хөгжүүлэх сангаас олгосон 52940,1 мянган төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн, Тэшиг сумын сургууль хэрэгцээнээс илүү гарсан махыг худалдан борлуулснаас эргэн тооцоогүй 1773,6 мянган төгрөг.

Үр нөлөө: Зээлийн сан бүрдэхгүй, дахин хувиарлагдахгүй, сургуулиас худалдсан мах данс бүртгэлгүй болох магадлалтай.

Ноцтой зөрчил: Булган сумын 1-р сургуулийн нярав дотуур байрны гал тогоонд хүүхдийн хоолны мах дутуу олгосон ч нормоор олгосон мэт баримт бүрдүүлэн тайлан гаргасан, Хишиг-Өндөр сумын Сум дундын эмнэлгийн нягтлан бодогч цалингийн тооцооны гарт олгох хүснэгтийн өөрийн нэрэн дээр 2015-2016 онуудад 5577,4 мянган төгрөгийг хууль бусаар нэмж аван ашиглал үүсгэсэн

Гурав. Удирдлага зохион байгуулалт

Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн хэрэгжилт: Тайлант хугацаанд 3 сум, 1 тосгонд 44 байгууллагад хяналт шалгалт, дотоод аудит хийлээ. Аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу хэрэгжүүлбэл зохих 80 арга хэмжээнээс, тусгай захиалгат 64, тусгай арга хэмжээнээс бусад 16 арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнгийн гэрээний биелэлт 87,8 хувьтай байна.

Тайлант хугацаанд хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан 53 хяналт шалгалтаас 44 хяналт шалгалт хийсэн ба төлөвлөгөөт бус 12 хяналт шалгалт хийв. Төлөвлөгөөт бусаар Бугат сумын ЗДТГ, ЭМТ, СБС, ОНХС-д, Баяннуур сумын Цэцэрлэг, Булган сумын 1-р сургууль, НДХ, Хишиг-Өндөр сумын

Сум дундын эмнэлэг, ХХҮГ, Аймгийн ЗДТГ, ХААА-дад байгууллагуудад шалгалт хийлээ.

Нэгдсэн удирдамжаар ГХБХБГ, ОБГ-т хяналт шалгалт хийж хяналт шалгалтын материалыг Сангийн яамны ТХЭУГ-т хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд аймгийн төвийн цэцэрлэгүүдэд нэгдсэн шалгалт хийж БСУГ,СТСХ-т санал хүргүүллээ. Бусад шалгалттай холбоотой асуудлаар бодлогын асуудал хариуцсан агентлагуудад 14 удаа албан бичиг хүргүүлсэн байна.

Хууль, тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангаагүй зөрчлийг арилгуулахаар 118 заалттай 31 албан шаардлага өгсөн ба албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна. Мөн 104200,9 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн 81 акт тогтоосноос 75,1 хувийг барагдуулж, хугацаа хэтэрсэн 9092,5 мянган төгрөгийн төлбөрийг Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184.2-дох заалтын дагуу Шүүхээр баталгаажуулахаар хүргүүллээ.

Хяналт шалгалтын удирдамж 22, танилцуулга 39, ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн мэдэгдэл 52-г үйлдлээ.

Орон нутгийн төр захиргааны байгууллагын шийдвэр гаргуулсан байдал: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдлын талаар мэдээлэл, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар шалгалтын дүн, үр дүнгийн гэрээний биелэлтийг хэлэлцүүлжээ.

Хууль тогтоомжийг хангуулахтай холбоотойгоор аймаг орон нутгийн хэмжээнд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулахаар аймгийн Засаг даргын Албан даалгаврын төсөл боловсруулан батлуулав.

Дөрөв. Төсөв санхүүгийн үйл ажиллагаа

Тайлант онд 76013,3 мянган төгрөгийн төсөв батлагдаж , оны эхний үлдэгдлээс нэмж 10435.8 мянган төгрөгөөр тодотгол хийгдэж 86449.2 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласнаас нийт 86303.3 мянган төгрөгийг зарцуулж 145.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

Зардлыг зүйл ангиар нь дурьдвал: Цалин 64497.9 мянган төгрөг, ЭМНДШ 7095.6 мянган төгрөг, бичиг хэргийн зардал 679.1 мянган төгрөг, тээвэр шатахуун 2200.0 мянган төгрөг, шуудан холбоо 951.6 мянган төгрөг, албан томилолт 5573.5 мянган төгрөг, тавилга эд хогшил 4500,0 мянган төгрөг, мэдээллийн технологи 115.5 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 690.0 мянган төгрөг нийт 86303.2.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах зорилгоор хоолны хөнгөлөлтийг өдрийн 1500 төгрөгөөр тооцож нийт 1774,7 мянган төгрөг, 3 ажилтанд салбарын тэргүүний ажилтаны шагналд 300,0 мянган төгрөг, 2 ажилтанд аймгийн ИТХ-ын хүндэт жуух бичиг, баярын бичгийн дагалдах мөнгөн шагнал 150.0 мянган төгрөг, 2

ахмадад хүндэтгэл үзүүлж 120,0 мянган төгрөгийг тус тус олгосон байна. Авлага өглөггүй ажилласан байна

Тав. Бусад мэдээлэл

Тайлант хугацаанд хариутай болон илгээсэн, ирсэн албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлт, удирдамж, танилцуулга, улсын байцаагчийн акт, албан шаардлагын бүртгэл зэрэг бүртгэлүүдийг цаг тухай бүр тасралтгүй хөтлөж хэвшүүлсний зэрэгцээ гүйцэтгэлд хяналт тавьж, 7 хоногийн төлөвлөгөө, шуурхай мэдээг гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст, улирлын хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт, тоон болон бичмэл тайланг заасан хугацаанд нь гарган Сангийн яаманд тус тус хүргүүлэн нэгтгүүлэв.

2016 оны 01 дүгээр сараас шинэчлэгдсэн Шилэн дансны шинэ системд мэдээлэл хөрвүүлэх, нөхөн байршуулах ажлыг аймгийн түвшинд зохион байгуулж, 1 дүгээр улирлын тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд тэтгэвэр тогтоолгоод давхар төсвийн байгууллагад ажиллаж байгаа ажиллагсдын судалгааг гаргаж Сангийн яаманд хүргүүлээ.

Зургаа. Дүгнэлт

Ажилтнуудтай байгуулсан үр дүнгийн гэрээг 89-94 хувиар, аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээг 87,8 хувиар биелүүлсэн байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажилаа бүрэн хэрэгжүүллээ. Албаны ажилтнуудын ажлын хариуцлага сахилга, ёс зүйг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч дотоодын хяналт тавьж ажиллалаа.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, таслан зогсоох талаар бодлогын чанартай асуудлуудыг аймгийн удидлагууд, холбогдох хэлтэс агентлагт тавьж хамтран ажиллаж байна.

Хяналт шалгалтын үр дүн өсөж, шалгалтанд хамрагдсан байгууллага, аж ахуйн нэгжид зөрчил буурч байгаа ч шалгагдсан байгууллагуудын дотоод хяналт сул, хууль дүрэм, журам, стандартаа судалдаггүй байна.

2016 онд шалгагдсан байгууллагуудад илэрсэн зөрчлийн 33 хувь нь цалин хөлс, албан томилолттой холбоотой зөрчил илэрч байгаа нь нягтлан бодогчдын ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.

Шилэн дансны нэгдсэн вэб сайтад хөрөнгө мөнгө захиран зарцуулсан шийдвэрүүд, хяналт шалгалтын материал манай байгууллагын шаардлагаар мэдээлж байна.

